

ТЕХНОЛОГИЙН ФИЛОСОФИ

Г.ГАН-ЭРДЭНЭ

Хилийн цэргийн 0151 дүгээр ангийн захирагч, Хил судлалын докторант, хурандаа

Хураангуй:

Бидний амьдарч буй өнөө үеийг мэдлэгийн тухайлбал, техникийн мэдлэгийн хувьсгалын үе гэж товчоор тодорхойлж болно. Мэдлэгийн хувьсгалын өнөө үед мэдлэг нь орлогын эх үүсвэр болж байгаа бөгөөд хөгжингүй орнуудын хувьд хөгжлийг тодорхойлох гол хүчин зүйлүүдийн нэг бөгөөд шинжлэх ухааны бүх талын мэдлэгийг бүтээгдэхүүн, үйлчилгээ, мэдээллийг үйлдвэрлэх, хуваарилах, хэрэглэх зорилгоор ашигладаг технологийн хөгжлийн үндэс болж байна.

Техник, технологийн философийг Цэргийн холбоо, мэдээллийн системийн онолын үндэстэй судалж, улсын хил хамгаалалтын удирдлага, холбоо зохион байгуулалт, техник технологийн ашиглалтад анхаарах асуудлуудыг товч хөндөж, энэхүү зорилгыг биелүүлэхийн тулд орчин цагт шинээр үүсэж, ашиглагдаж байгаа дэвшилтэт техник хэрэгслийг холбоо, мэдээллийн системд хэрхэн нэвтрүүлж, хослуулан ашиглах санал боловсруулах болно.

Түлхүүр үг: Технологийн философи

ОРШИЛ

Физикийн философи, биологийн философи зэрэг философийн олон салбаруудын

нэгэн адил технологийн философи нь судалгааны харьцангуй залуу салбар юм. Энэхүү салбар нь 19-р зууны хоёрдугаар хагаст танигдахуйц гүн ухааны мэргэшил болж үүссэн гэж үздэг бөгөөд түүний гарал үүсэл нь ихэвчлэн Эрнст Каппын Grundlinien einer Philosophie der Technik (Капп, 1877) ном хэвлэгдсэнтэй холбоотой байдаг. Технологийн философи нь одоог хүртэл хөгжиж буй салбар хэвээр байгаа бөгөөд философи хийх олон янзын хэв маяг зэрэгцэн оршиж байгаагаараа онцлог юм. Өөрөөр хэлбэл, "технологийн философи" гэдэг нь технологийн талаар ямар нэгэн байдлаар тусгадаг олон төрлийн гүн ухааны оролдлогуудыг илэрхийлдэг.

Тиймээс философичид, шинжлэх ухаан, технологийн чиглэлээр ажилладаг эрдэмтэд, түүнчлэн инженерүүдийн дунд технологийн философи гэж юу болох, энэ нь юу биш, юу байж болох, юу байх ёстой талаар хэлэлцүүлэг үргэлжилсээр байна. Эдгээр асуултууд нь энэхүү өгүүлэлд тухайн салбарыг танилцуулах суурь болно гэж үзэж байна.

Үндсэн хэсэг

Технологийн философи нь анх XIX зууны хоёрдугаар хагаст Германд Эрнст Каппын "Инженерийн философийн үндэс" ном хэлбэрээр гарч ирснээр үүссэн гэж үздэг. Учир нь түүнд "технологийн философи" (буюу "техникийн философи") гэсэн нэр томьёо анх нэвтэрсэн. Капп үүнийг хүн төрөлхтний нийгэмд технологийн ашиглалтын

нөлөөллийн талаарх гүн ухааны судалгааг илэрхийлэхэд ашигласан ба түүндээ Шотландын химийн инженер, Эндрю Урийг энэ хүрээнд Капп дурдсан байдаг. Хэд хэдэн хүний хувьд Каппын бүтээл хэвлэгдсэнээс хойш хэдэн арван жилийн дараа технологид чиглэсэн философийн бүтээл гарсан боловч тийм ч их хэвлэгдээгүй бөгөөд энэ салбар 20-р зуун хүртэл сайн хөгжиж чадаагүй юм. Түүний дараагаар технологийн философийн талаар гол хэвлэлүүд анх Германд гарч ирсэн юм. (жишээлбэл, Дессауэр, 1927; Жасперс, 1931; Дизель, 1939).

Платон, Аристотель нарын “Технологи нь байгалийг дуурайлган хийдэг” гэсэн үзэл баримтлал нь Дундад зууны туршид давамгайлж байсан бөгөөд хожим нь батлагдсаар байв.

Дэлхийн 2-р дайны дараа технологийн талаар нийтэлсэн эргэцүүллүүдийн тоо огцом өссөн нь дэлхийн хоёрдугаар дайнд технологи маш чухал үүрэгтэй байсныг, хүн төрөлхтний нийгэмд технологийн нөлөөллийг хүчтэй үзүүлсэн гэдгийг харуулж байна. Мөн технологийн түүхчид Дэлхийн 2-р дайныг хүн төрөлхтний түүхэн дэх технологийн хувьд хамгийн шинэлэг үе гэх бөгөөд дайны үед олон олон технологийн инновацыг хөгжүүлсэн, шинэ технологиудыг нэвтрүүлж, дараа нь хэдэн арван жилийн турш ийм инновац руу улс орнуудыг чиглүүлсэн гэж үздэг. Иймээс Дэлхийн 2-р дайн ба түүнээс хойших үе нь 21-р зууны эхэн үед технологи нь тэргүүлэх түвшинд хүрч, улмаар философийн

гол сэдэв болсон юм. Ихдэ бичсэнчлэн энэ нь "анхаарахгүй байж болохгүй чухал хүч" болсон.

Техникийн философид дараах арга зүйн асуудлууд багтдаг. Үүнд:

- Шинжлэх ухаан ба техникийн шүтэлцээ

- Байгаль шинжлэл ба техникийн шинжлэх ухааны харилцан холбоо

- Техникийн шинжлэх ухаан дахь онолын ба хавсарга судалгааны онцлог

- Шинжлэх ухаан техникийн бүтээлч үйл ажиллагааны нийгэм-философийн асуудлууд

- Техник болон инженерийн үйл ажиллагаанд өгөх ёс зүйн ба гуманитар дүн шинжилгээний асуудлууд

- Инженерийн үйл ажиллагааны нийгэм, экологи болон бусад үр дагаврын асуудлууд зэрэг болно. Товчоор хэлбэл, техникийн философи нь техникийн нийгмийн философи, техникийн ёс зүйн асуудлууд дээр тулгуурладаг гэж хэлж болно.

Техникийн философи нь үүссэн үеэсээ эхлэн хүн төрөлхтөнд чиглэгдсэн техник бөгөөд техникийн философийн гол зорилт нь ертөнцөд хүн-техникийн хандах харьцаа буюу ертөнцийг техникээр ойлгохуй юм. Энэ нь техникээс татгалзах биш, хүний бүтээж хөгжүүлж ирсэн иргэншил өөрөө ертөнцтэй техникээр дамжуулан харилцахгүй байх боломжгүй, харин ч энэхүү харилцааг шинэ, хүмүүнлэг хэлбэрээр баяжуулан өөрчлөн байгуулах арга замыг эрж хайх, үүний тулд өнөөгийн техникийн шинжлэх ухаан,

инженерийн үйл ажиллагааны дотоод бүтцийн чиг зорилгыг өөрчлөхөд гол анхаарлаа төвлөрүүлдэг гэсэн санааг илэрхийлж байгаа юм.

Энэхүү зорилтыг шийдвэрлэхэд инженерийн сэтгэхүйн хуучин чиг баримжааг шинэчилснээр шийдвэрлэх боломжтой. Энэ нь юуны өмнө инженерийн боловсролыг нэмэгдүүлэхийг хэлж буй хэрэг юм. Инженерийн боловсролоос эх авсан инженерийн сэтгэхүйг өөрчлөн зохион байгуулахын зорилго нь инженерийн техникийн ухамсрыг шинээр төлөвшүүлэх явдал гэж үздэг. Инженерийн техникийн ухамсрыг төлөвшүүлэх үйл явц гэдэг нь техникийн дээд сургуулийг төгссөн боловсон хүчин хүн төрөлхтний түүх, орчин үеийн соёлт техник, техникийн үйл ажиллагаа, техникийн мэдлэгийн эзлэх байр суурийг тодорхойлох чадварыг эзэмшихийг хэлдэг.

Дээрх тайлбараас үзвэл техникийн философи нь техник, техникийн үйл ажиллагаа, техникийн мэдлэг хэмээх гурван объектоороо дамжуулан инженерүүдийн техникийн ухамсрын хөгжлийг судлагдахуун болгодог философийн шинжлэх ухааны нэг салбар мөн гэж тодорхойлж болно.

Үүнээс үүдэн техникийн философийн үндсэн хүрээнүүдийг дараах байдлаар ангилж болно. Үүнд:

- Соёл ба техник (түүх- соёл ба нийгэм соёлын асуудлууд)
- Техникийн философийн арга зүйн асуудлууд (техникийн

шинжлэх ухаанууд ба төсөл боловсруулалтын асуудлууд)

- Техник, түүний үр дагаварт өгөх нийгмийн үнэлгээний асуудлууд

- Инженерийн ёс зүй (нийгмийн хариуцлагын асуудлууд) хэмээх хүрээнүүд багтдаг.

Техник технологийн хөгжил нь шинжлэх ухааны мэдлэгээс гадна газарзүй, нийгэм соёл, түүхийн хүчин зүйл ба хувь хүн, нийгэм, иргэншлийн аюулгүй байдлын асуудалд давхар нөлөө үзүүлж байна. Өөрөөр хэлбэл, техник, технологийн хөгжлийг даган хүн, түүний хүрээлэн буй орчны аюулгүй байдлын тухай шинжлэх ухааныг хослуулан судлах хэрэгцээ шаардлага үүсэж байна гэсэн үг юм.

Аюулгүй байдлыг хангах нь учирч болзошгүй аюул, заналыг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, няцаах, устгах талаар хувь хүн, нийгэм, улс орон, дэлхийн хамтын нийгэмлэгийн үйл ажиллагаанд тулгуурлан шинжлэх ухааны олон салбарыг хамарсан асуудал болж буй учир техник, технологийн философитой уялдуулан судлах нь зүйн хэрэг юм. Аюулгүй байдлын объектуудын амин чухал эрх ашгууд үндэсний аюулгүй байдлын тогтолцоонд голлох байр эзэлдэг. Мөн хилийн аюулгүй байдал нь Үндэсний аюулгүй байдлын салшгүй нэг хэсэг бөгөөд үндэсний ашиг сонирхол, түүнд учрах аюул заналыг төвлөрүүлсэн нийгмийн харилцаа



(хилийн хүрээ)-ны тодорхой орчин хамаарч байгаа болохоор хилийн аюулгүй байдлыг үндэсний аюулгүй байдлын "бие даасан төрөл" гэж онцлох нь зүйтэй юм.

Хилийн аюулгүй байдал бол үндэсний болон бүс нутаг, дэлхийн төвшний төрөл бүрийн субъектүүд, тэдний харилцан ажиллагааны үр дүн мөн.

Хилийн аюулгүй байдал, үндэсний аюулгүй байдлын нэгэн хэсэг гэдгийг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ, тэр нь үндэсний аюулгүй байдлын тогтолцоонд зөвхөн нэгэн хэсэг төдийгүй, өөрийнхөө объектуудаар үндэсний аюулгүй байдлын бусад хэсгүүдийн агуулгыг бүрэн хамардаг онцлогтой, түүний нэгдмэл бүрэлдэхүүн хэсэг болно.

XX зууны сүүлээс үндэстэн, хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, террорист халдлага, хууль бус шилжилт хөдөлгөөн, хар тамхи, мансууруулах бодис, зэвсэг, сум, галт хэрэгслийн хууль бус эргэлт, хүний наймаа, цахим халдлага зэрэг шинэ төрлийн гэмт хэргийн гаралт өсөн нэмэгдэх болсны улмаас дэлхийн зарим улс

орнууд хилийн аюулгүй байдлаа бие даасан, дангаар хангах арга хэлбэрийг сонгож, инженер, техникийн байгууламж, хана, саадыг байгуулах, автоматжуулалт, дэвшилтэт техник, технологи, хиймэл оюун ухаанд суурилсан хяналт, удирдлагын цогц системийг бүрдүүлэхэд ихээхэн ач холбогдол өгч байна. Үүнтэй зэрэгцэн цэргийн холбооныхоо техник хэрэгслүүдийг улам боловсронгуй болгох асуудалд ихээхэн анхаарал хандуулж, энэ талаар судалгаа шинжилгээ туршилт, зохион бүтээх ажил тасралтгүй хийгдсээр байна.



Тиймээс цэргийн холбооны систем, тэр тусмаа хилийн цэргийн холбооны системийг сүүлийн үеийн техник, технологийн философийн хөгжил, хилийн болон холбоо, мэдээллийн аюулгүй байдалтай системтэйгээр хослуулах чухал шаардлага үүсэж байна.

Цахим шилжилтийн үйл явц үйлдвэрлэл, эдийн засаг, батлан хамгаалах, аюулгүй байдал зэрэг төрийн салбаруудыг хамран нийгмийн бүх талбарт гүн гүнзгий нөлөөлж байна. Энэ байдлыг харгалзан төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагууд орчин үеийн, харилцан ажиллагаа бүхий, батлан хамгаалах зорилгод чиглэсэн мэдээлэл, харилцаа холбооны технологид суурилсан эрэмбэлэгдсэн тогтоцтой байхаар шинэчлэл хийсээр байна. Сүлжээний хурдацтай хөгжил нь автоматжуулсан систем бүрийг халдлагад өртөж болзошгүй талбар болгон хувиргаж, мэдээллийн технологи нь хүмүүсийн амьдралд улам их хамааралтай болж, бодит байдал нь мэдээллийн дайнд оролцогч бүхэн цэрэг биш, компьютер ойлгодог хүн бүхэн

сүлжээн дэх тэмцэгч болж болзошгүйг харуулна.

Холбоо, мэдээллийн технологийн арга хэмжээ нь улсын хил хамгаалалтыг удирдан зохион байгуулах үндсэн арга, тэргүүлэх чиглэл бөгөөд Хил хамгаалах байгууллагын хөгжлийн түвшнийг тодорхойлох шалгуурын нэг болж байна.

Манай улсын хувьд улсын хил хамгаалалтдаа инженер, дохиолол-хяналт, мэдээллийн технологийн сүүлийн үеийн хэрэгсэл цэргийн хяналтаа зохион байгуулахад ашиглаж байгаа бөгөөд Хил хамгаалах байгууллагын хөгжлийн чиг хандлага нь үүлэн технологи, цахим аюулгүй байдал, их өгөгдөл, хөдөлгөөнт байдал, виртуалчлал, хиймэл оюун ухаан, робот техник гэсэн чиглэл рүү тэмүүлж байна. *Шинэ эрин, шинэ нөхцөл байдалд улсын хил, түүний аюулгүй байдлын шинж төлөв, чанар ихээхэн өөрчлөгдөж байна. Хиймэл дагуул, нисэх онгоц, нисдэг тэрэг, нисгэгчгүй нисэх хэрэгсэл, дохиолол-хяналтын хэрэгслийг ашиглах нь хүн хүч, зардал мөнгөнд хэмнэлттэй боловч технологийн*

хувьсал нь мэдээллийн дайн, тэмцлийн шинэ талбарыг бий болгож байна. Мөн манай хөрш гүрнүүд ОХУ, БНХАУ, болон АНУ гэх зэрэг дэлхийн хүчирхэг гүрнүүд дайсны хиймэл дагуулыг устгаж чадах сансарт суурилсан зэвсгийн системийг бүтээхээр уралдаж байна. Цэрэг, тагнуулын зориулалт бүхий хиймэл дагуулуудад цэргийн арга хэмжээ авах, дэлхийд унагах, удирдлагагүй болгох эрсдэл үүсэж байгаа тул Хилийн цэргийн холбоо, мэдээллийн технологийн системд хиймэл дагуул, хиймэл оюун ухаанд суурилсан техник, технологийг дангаар нь ашиглах нь маш том эрсдэл дагуулж болзошгүй юм.

Мөн олон улсууд цэргийн салбартаа хиймэл оюун ухааны технологиудыг ашиглах болон эзэмших зорилгоор олон талын арга хэмжээг боловсруулан, хэрэгжүүлж эхлээд байна. Жишээ нь: Дайны системүүд, стратегийн шийдвэр, тооцоолон бодогч систем, мэдээлэл боловсруулах, судлах, байлдааны симуляци, Аюулаас урьдчилан сэргийлэх удирдлагын хяналт, дронуудын бүлгүүд гэх мэт. Дайсагнасан орчинд маш чухал даалгавруудыг гүйцэтгэх чадвартай, эрчим хүч бага зарцуулагддаг, найдвартай, хүчирхэг хиймэл оюун ухааны системийг бий болгохын тулд үйлдвэр, лаборатори, компаниудыг эрчимтэй татан оролцуулж байгаа. Ингэхийн тулд бидэнд чадвартай инженер, хүний нөөц хэрэгтэй бөгөөд шаардлагатай гэж үзэж буй бүхий л салбарт хиймэл оюун ухааныг ашиглахын тулд мэргэжилтэн бэлтгэх, тусгай

мэргэжилтэн, инженерүүдээс бүрдсэн багийг бүрдүүлэх шаардлагатай бөгөөд манай улс нь үйлдвэрлэгч биш, шинжлэх ухаан, тэр дундаа холбоо мэдээллийн технологийн салбар нь хараат байгаа байдлаас үзэхэд хиймэл оюун ухаан, ямар нэгэн мэдээллийн системийн өөрөө гүйцэтгэгч функц нь дангаараа үүрэг гүйцэтгэх ямар ч боломжгүй юм.

Цэргийн холбооны системийг шинжлэх ухааны талаас нь товчхондоо хэлбэл:

Цэргийг удирдлагаар хангахын тулд үүрэг, байр, ажиллах хугацаагаар нь нягт уялдуулан зохицуулж, нэгдсэн бодлого, төлөвлөгөөгөөр дэлгэн байгуулсан төрөл бүрийн зориулалттай холбооны станц, зангилгаа, шугамын нэгдлийг холбооны систем гэнэ. Систем нь иж бүрдэл, бүтэц, арга гэх мэт олон утгатай байна. Нийтлэг зорилгын төлөө зохион байгуулсан элементүүд буюу бүрэлдэхүүн хэсгүүдийн нэгдлийг систем гэнэ. Системийг бүрдүүлэх элементүүд нь тодорхой зорилгыг хэрэгжүүлэхийн тулд харилцан холбогдож, эмх замбараатай ажиллагааг хийдэг нэгдэл бөгөөд систем болсноор элемент тус бүр дангаараа хийж чадахгүй ажлыг гүйцэтгэж чадна.

Дээрх 2 тодорхойлолтыг нэгтгэн дүгнэхэд цэргийн удирдлагын холбооны системийн техникийн философи нь холбооны бэлэн байдалтай нягт уялдсан цогц систем юм.

Иймд улс орны хэмжээнд гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдох, хил дамнасан гэмт

бүлэглэл, террорист ажиллагаа, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэх нөхцөл, Монгол Улсад ажиллаж байгаа цахилгаан станцууд зогсох, үүрэн телефоны оператор компаниуд ажиллагаагүй болох зэрэг эрсдэлтэй үед Хил хамгаалах байгууллагын холбоо мэдээллийн систем бүх шатандаа тасралтгүй хангагдаж үлдэх бүрэн чадвартай байх шаардлага нь Улсын хилийн аюулгүй байдлын гол үзүүлэлт юм.

Холбооны системийн цогц арга хэмжээ нь өөрөө үндсэн холбоо ба бусад холбооны төрөл, мэдээлэл технологийн арга хэрэгслүүдтэй нягт уялдсаны үндсэн дээр холбооны бэлэн байдлаа бүрэн хангадаг тул дан ганц мэдээллийн технологи, аль эсвэл радио холбоо, сансрын холбоогоор зохион байгуулах боломжгүй юм. Өөрөөр хэлбэл цэргийн холбооны гол зарчмын нэг болох холбооны бэлэн байдал нь харилцаа, холбоо мэдээллийн технологийн бүх төрлийг цагийн байдлын ямар ч үед тохируулан (техникийн философи) хослуулан хэрэглэх шаардлагатай гэсэн үг юм. Тиймээс орчин үеийн хиймэл оюун ухаанд суурилсан систем, техник, роботик төрлүүдийг дээрх цогц арга хэмжээнд хослуулан ашиглах нь техникийн философийн хувьд зүйн хэрэг юм.

Дүгнэлт

Орчин үед техник нь органик бус ертөнцөөс эхлээд ахуй болон хүмүүсийн харилцааны бүх л салбарыг хамарсан өргөн хүрээтэй ойлголт болох нь харагдаж байна. Энэ олон шинж бүхий ойлголт дахь

чухам ямар харилцааг техникийнх гэж бид үзэж болох вэ?

Нэгдүгээрт: Техник нь ямагт хүний оюун ухаан, байгаль хоёрын нэгдлийн үр дүн байдаг.

Хоёрдугаарт: Техник нь хүнд ашиглагдаж, хэрэглэгдэж байдаг. Өөрөөр хэлбэл, байгалийн зүйлийг хүмүүст хүртээмжтэй чөлөөтэй хэрэглэн ашиглах бололцоог олгох зорилготой.

Гуравдугаарт: Техникийн мөн



чанар нь түүний объектив хийгээд субъектив талуудын харилцаа холбоонд оршино. Энэ нь нэг талаас, тухайн техникийг бүтээн ашиглаж хэрэглэх хүний чадвар, нөгөө талаас, хүнээс шалтгаалахгүй хүнийг өөрийг нь залан жолоодож буй объектив буюу байгалийн чадвар, эдгээрийн харилцан үйлчлэлд илэрнэ.

“Техникийн” тухай ойлголт нь хүн, байгаль хоёрын нэгдэл, эдгээрийн харилцаа холбоогоор тодорхойлогдож байгаа нь философийн уламжлалт үндсэн асуудалтай бас холбоотойг нотлон харуулж байна.

Мөн мэдээллийн технологийн хөгжил нь шинжлэх ухаанаас илүүтэй, нийгмийн шинжлэх ухаантай хамааралтай болж, өөрөөр хэлбэл мэдээллийн аюулгүй байдлыг зөвхөн кибер аюулгүй

байдлаар хязгаарлах боломжгүй бөгөөд мэдээллийн аюулгүй байдлын хүмүүнлэг тал нь түүний чухал бүрэлдэхүүн хэсэг болоод байна.

Дэлхийн улс орнуудын цэрэг, эдийн засгийн хүчин чадал өгөгдөлд суурилж, компьютер, автомат системүүд, өгөгдөл, холбооны сүлжээгээр дамжин хөдөлгөөнт холбоо бүхий роботуудтай нэгдэж, дайн, байлдааны шинэ арга хэрэгсэл бий болж байгаа өнөө үед дижиталчлал нь хөгжил дэвшлийг хөдөлгөгч хүчин зүйл болж байна. Иймд одоо ашиглаж байгаа мэдээлэл технологийн болон цаашид хиймэл оюун ухаанд түшиглэсэн хэрэгслүүдийг улсын хил хамгаалалтыг зохион байгуулахад ашиглахдаа дэлхийн түвшинд биш, харин тодорхой бүс нутаг, өөрийн орны онцлог, технологиудын тодорхой нөхцөл байдалд судалж, илүү орон нутгийн түвшинд хийх ёстой юм. Учир нь хилийн аюулгүй байдлыг хангаж буй удирдлагын холбооны системийн техникийн философи нь өөрөө холбооны цогц арга хэмжээ бөгөөд дангаараа холбооны бэлэн байдлыг хангах боломжгүй юм. Мөн онц байдал /онцгой нөхцөл/ үүссэн үед иргэний болон Батлан хамгаалах салбарын холбооны системүүд нь хоорондоо нийцэлтэй ажиллаж чадахуйц, найдвартай, хүртээмжтэй өргөн зурвасын холбоогоор хангагдсан байх нь хувь хүмүүс байгууллагыг болзошгүй онцгой нөхцөлийн үеийг даван туулахад чухал нөлөө үзүүлэх болно.

Иймд ердийн болон онц байдал /онцгой нөхцөл/ үүсэх үед холбооны техник хэрэгслүүдийг цагийн байдлын өөрчлөлтөөс шалтгаалан цогц байдлаар удирдаж, холбооны системийн ачааллыг тохируулан багасгаж, ажиллагааны явцад амь бөхтэй байх шаардлага хангагдаж, ажиллагаанд тогтвортой, мэдээллийг дамжуулах боломжоор хангах нь нэн тэргүүний асуудал болж байна.



Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.6-д “Мэдээллийн салбарт үндэсний ашиг сонирхлыг хамгаалах, төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулах нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэс мөн” гэж тодорхойлсон. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3.4-д үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэгт мэдээллийн аюулгүй байдлыг хамааруулсан байна. Мэдээлэл, харилцаа холбооны орчин үеийн технологийг ашиглан үндэсний мэдээллийн нөөц баялаг, түүний эрх ашигт заналхийлэх аливаа халдлагаас хамгаалах асуудал өдгөө нэг үндэстний хэмжээнд бус, дэлхийн олон улсын

өмнө хурцаар тавигдаж, уг асуудлыг эрх зүйгээр төрөлжүүлэн зохицуулах, технологийн оновчтой шийдлийг хослуулан хэрэглэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Мөн иргэний, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн

технологи, харилцаа холбооны мэргэжилтнүүд хамтарч олон талт үүрэг гүйцэтгэх харилцан ажиллагааны холбоог зохион байгуулах, холбооны нийцлийг хангах зэрэг асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай гэж дүгнэж байна.